

Golomt Capital®

# ДЭЛХИЙН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ

2025.11.10

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Хиймэл оюун ухаанд чиглэсэн хөрөнгө оруулалтын зардал анхаарал татаж, үнэлгээ өндөрт хүрсэн тухай болгоомжлол өссөн технологийн хувьцаанд дарамт үзүүлэв. Технологийн компаниуд давамгайлсан Nasdaq Composite хамгийн их унасан.
- Зөвхөн аравдугаар сард 153 074 ажлын байр цомхотгосон нь 2003 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Үйлчилгээний салбар өсөлтөд эргэн орлоо, харин үйлдвэрлэл найм дахь сардаа агшив.
- Аравдугаар сард ажлаас халагдсан хүний тоо 20 жилийн дээд түвшинд хүрлээ. Засгийн газрын мэдээлэл хязгаарлагдмал хэвээр байгаатай холбогдуулан хөрөнгө оруулагчид энэ долоо хоногт хувийн байгууллагуудын мэдээлэлд илүү анхаарлаа хандуулав.
- АНУ болон Хятад улсын харилцан нэг жилийн хугацаанд худалдааны дайн хийхгүй гэсэн тохиролцоо нь зах зээлд итгэл өглөө. АНУ болон Хятад улс худалдааны маргаанаа нэг жилийн хугацаанд царцаахаар тохиролцсоны дараа хөрөнгө оруулагчдын сэтгэл зүй мэдэгдэхүйц сайжрав.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>

Таамагласан ханшид хүрсэн.  
Дээд таамаглал **7,000** байна





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.11.03-11.09

### АНУ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА СЭРГЭЖ МАГАДГҮЙ.

Хувьцааны зах зээл өмнөх гурван долоо хоног дараалан өсөлтөө ганцхан долоо хоногийн уналтаар үгүй хийлээ. АНУ-ын хөрөнгийн зах зээл өмнөх долоо хоногт 3 орчим хувийн уналттай хаагдав. Хиймэл оюун ухаанд чиглэсэн хөрөнгө оруулалтын зардал анхаарал татаж, үнэлгээ өндөрт хүрсэн тухай болгоомжлол өссөн технологийн хувьцаанд дарамт үзүүлэв. Технологийн компаниуд давамгайлсан Nasdaq Composite хамгийн их унасан бол үнэ цэн дээр төвлөрсөн индекс арай бага уналттай байлаа.

Энэ нь 2-р сараас хойших индекс дээр үүссэн хамгийн өргөн зөрүү юм. Засгийн газрын үйл ажиллагаа зогссон түүхэн дэх хамгийн урт хугацаанд үргэлжилж байна. АНУ-ын холбооны засгийн газрын хаалт урт хугацаанд үргэлжилж байгаа нь хөрөнгө оруулагчдын сэтгэл зүйд дарамт болов. Сүүлийн хэдэн долоо хоногийн турш энэ талаарх мэдээ бага байсан ч ойрын үед засгийн газрын үйл ажиллагааны зогссон нөлөөний талаарх сурвалжлага эрчимжиж, ялангуяа Нисэхийн холбооны захиргаа (FAA) нисгэгчийн хяналтын ажилтнуудын хомсдолоос үүдэн агаарын хөдөлгөөнийг бууруулах тушаал гаргасан нь анхаарал татав.

Мөн засгийн газрын статистикийн мэдээлэл саатаж байгаа нь ДНБ-ийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөөлнө гэсэн таамаглал нэмэгдлээ. Аравдугаар сард ажлаас халагдсан хүний тоо 20 жилийн дээд түвшинд хүрлээ. Засгийн газрын мэдээлэл хязгаарлагдмал хэвээр байгаатай холбогдуулан хөрөнгө оруулагчид энэ долоо хоногт хувийн байгууллагуудын мэдээлэлд илүү анхаарлаа хандуулав.

ADP-ийн аравдугаар сарын хөдөлмөрийн тайланд хувийн хэвшил нийт 42 000 ажлын байр шинээр бий болгосон гэжээ. Хоёр сар дараалан буурсны дараах сэргэлт юм. Гэвч энэхүү өсөлт өргөн хүрээтэй биш байв: мэргэжлийн үйлчилгээ, мэдээлэл, аялал жуулчлалын салбар гурав дахь сардаа ажлын байраа цөөлсөн бөгөөд цалингийн өсөлт өөрчлөгдсөнгүй. Харин Challenger, Gray & Christmas компанийн тайлангаас үзвэл, ажил олгогчид 2025 оны аравдугаар сар хүртэл нийт 1.1 сая орчим ажлын байр цомхотгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 65 %-иар, 2024 оны бүтэн жилийн дүнгээс 44 %-иар их байна.

Зөвхөн аравдугаар сард 153 074 ажлын байр цомхотгосон нь 2003 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм. Үйлчилгээний салбар өсөлтөд эргэн орлоо, харин үйлдвэрлэл найм дахь сардаа агшив. Хангамжийн удирдлагын хүрээлэн (ISM)-гээс мэдээлснээр аравдугаар сард АНУ-ын үйлчилгээний салбарын эдийн засгийн идэвх өсөлтөд орж, PMI 52.4 % болж өмнөх сарын 50.0 %-иас өсөв (50-аас дээш үзүүлэлт өсөлт, доош нь агшилтыг илтгэнэ). Салбарын шинэ захиалгын индекс 56.2 % болж 2024 оны аравдугаар сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Энэ сард 11 салбар өсөлттэй байсныг тэмдэглэжээ (өмнөх сард – 10 салбар).

Харин үйлдвэрлэлийн салбар дараалан найм дахь сардаа агшиж, ISM-ийн үйлдвэрлэлийн PMI 48.7 % болж, 9-р сарын 49.1 %-аас буурав. Үйлдвэрлэлийн гарц болон нөөцийн бууралт нь энэхүү сарын бууралтад голлон нөлөөлжээ.



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.11.03 – 11.09

### БНХАУ-ЫН ТЕХНОЛОГИЙН САЛБАР ӨСЧ БАЙНА.

АНУ-БНХАУ-ын худалдааны маргаан зөөлөрсөнтэй холбоотойгоор эрсдэл буурч, БНХАУ-ын эх газрын хөрөнгийн зах зээл долоо хоногийг өсөлтөөр хаав. CSI 300 индекс 0.82%, Шанхайн нийлмэл индекс 1.08% өссөн гэж FactSet-ийн мэдээлэлд дурджээ. Харин Хонгконгийн Hang Seng индекс 1.29%-иар нэмэгдсэн байна. Энэ өсөлт нь CSI 300 индексийг бараг сүүлийн дөрвөн жилийн дээд түвшинд хүргэжээ, гэхдээ Хятадын эдийн засгийн өсөлтийн талаарх болгоомжлол хэвээр байна.

АНУ болон Хятад улсын харилцан нэг жилийн хугацаанд худалдааны дайн хийхгүй гэсэн тохиролцоо нь зах зээлд итгэл өглөө. АНУ болон Хятад улс худалдааны маргаанаа нэг жилийн хугацаанд царцаахаар тохиролцсоны дараа хөрөнгө оруулагчдын сэтгэл зүй мэдэгдэхүйц сайжрав. Энэ тохиролцоог хоёр улсын ерөнхийлөгчид өмнөх долоо хоногт БНСУ-д болсон Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АРЕС) дээд хэмжээний уулзалтаар хийсэн уулзалтын үеэр байгуулжээ. Хөрөнгө оруулалтын шинжээчдийн үзэж байгаагаар, уг уулзалт уур амьсгалаараа өөдрөг байсан ч бодит, тодорхой шийдэл бага гарсан байна. Харин хөрөнгө оруулагчдын анхаарах гол зүйл бол АРЕС-ийн хурлын үеэр харагдсан уян хатан, бодит үзэл хандлага юм. Улс орнууд дэлхий нийтийн өөрчлөлтөнд дасан зохицож, боломжтой газартаа худалдаа хийж, шаардлагатай газартаа эрсдэлийг хязгаарлаж байгаа нь илт ажиглагджээ. Урт хугацаандаа АНУ ба Хятадын хоорондын стратегийн өрсөлдөөн худалдаанаас цааш, бусад салбарт ч үргэлжилсээр байх магадлал өндөр гэж шинжээчид дүгнэсэн байна.



